



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/317

Булган сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх заалт, мөн хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан зарим төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг хавсралтад заагдсаны дагуу Булган сумын Засаг даргын Тамгын газарт олгосугай.


2.Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмын хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр зохион байгуулж, гэрээ байгуулан, хүлээн авахыг сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-т үүрэг болгосугай.

3.Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Худалдан авах ажиллагааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Баярцэнгэл)-д үүрэг болгосугай.

4.Хавсралтад тусгагдсан төсөл арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 08-ны ний/ өдрийн 137 дугаар
захирамжийн хавсралт

д/д	Төсөл арга хэмжээний нэрс	Нийт төсөвт өртөг	Тухайн онд санхүүжүүлэх төсөвт өртөг	ХАА-нд мөрдөх журам	Тайлан мэдээ ирүүлэх хугацаа	Эрх шилжүүлсэн сумдын дарга
Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалт						
1	Хөл газрын ургамалтай механик аргаар тэмцэх (Булган сум)	30,000.0	30,000.0	ХА	Сар бүрийн 25-ны өдөр	Булган сумын Засаг дарга П.Нөхөрлөлбаяр
2	Булган сумын төвлөрсөн хогийн цэгийн хог хаягдлыг дарж булах ажлыг шат дараатай хэрэгжүүлэх (Булган сум)	75,000.0	75,000.0	ХА	Сар бүрийн 25-ны өдөр	Булган сумын Засаг дарга П.Нөхөрлөлбаяр
НИЙТ ДҮН		105,000.0	105,000.0			